

МОНГОЛ УЛС ДАХЬ В.ИНЖАННАШИЙН СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Б.Хишигсүх¹

XIX зууны Монгол уран зохиолын тулгуур гурван баганын нэгэн болох (тайж В.Инжаннаши, Ноён хутагт Данзанравжаа, Ханчин ханбо С.Жамъянгарав нар болно.) их зохиолч Ванчинбалын Инжаннаши 1837-1892 оны хооронд аж төрж, бүтээж туурвиж байсан билээ.

Тэрбээр өөрийн ухамсарт амьдралын бүхий л он жилүүдэд Монгол утга соёлын их үйлсэд нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэж ирсэн томоохон бичгийн хүн, суут сэтгэгч, агуу их зохиолч байлаа. Их зохиолчийн намтар, бүтээл туурвил дэлхийн Монгол судлалын эрдэмтэд, судлаачдын анхаарлыг татаж, түүний намтар бүтээлийг судлах үйл ажиллагаа 1950-иад оны дунд үеэс сая эхэлж эдүгээ нэгэнт 60-аад жилийг ардаа орхисон байна.

Эзэн Богд Чингис хааны хорин найм дахь үеийн ач, алтан ургийн язгууртан, тайж Ванчинбалын Инжаннашийн намтар, бүтээлийн судалгааны ажлын шанг татаж, улмаар их зохиолчийн бүтээл туурвилыг уйгагүй эрж цуглуулах, сурвалжлан судлах нөр их үйлсийг эхлүүлж, В.Инжаннашийн судлал Монгол уран зохиолын судлалд жинтэй хувь нэмэр эзлэхийг анхааран мэдэж, Инжаннаши судлалыг дэлхийн түвшинд гаргаж ирэхэд өөрийн хичээл зүтгэл, нөр их хөдөлмөр, цаг хүчээн харамгүй зарцуулж Дэлхийн монгол судлаачдын сонорт анхлан хүргэсэн эрдэмтэн бол профессор Эрдэнэтогтох авгай болоод орчуулагч, судлаач Содбилиг гуай нар билээ.

Тэртээх 1955,1956 онуудад эрдэмтэн судлаач Эрдэнэтогтох, Содбилиг авгай нар их зохиолчийн уугуул нутаг болох Баруун Түмэдийн нутгаар удаа дараа явж,



ТАЙЛБАР: эрдэмтэн судлаач Эрдэнэтогтох абугай их зохиолч В.Инжаннашийн зохиол бүтээлийг сурвалжлан цуглуулж илжгэн тэргээр зөөвөрлөж байсан нь.


зохиол бүтээлийг нь хайн олж, судалгааны эх хэрэглэгдэхүүн, судлагдахуун өч төчнөөнийг цуглуулж энэ бүхэн дээрээ тулгуурлаад 1958 онд “Инжаннаши” нэртэй бэсрэг бүтээлийг анхлан хэвлэлд бэлтгэснийг Өвөрмонголын Ардын хэвлэлийн хорооноос эрхэлж гаргасан төдийгүй орчуулагч, судлаач Содбилиг авгай

“Чулуун ширээнээс нэгэн давхар асар хүртэл” нэртэй цуврал өгүүллийг “Монгол хэл

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

бичиг”-ийн эрдэм шинжилгээний цуврал бичигт тус тус хэвлүүлсэн нь нэгэнт олны хүртээл болсон байна.

Улмаар 1959 онд Монгол Улсын (хуучин нэрээр БНМАУ) нийслэл Улаанбаатар хотноо анх чуулсан Олон Улсын Монгол Хэл Бичгийн эрдэмтний анхдугаар их хурал дээр Эрдэнэтогтох авгай “Инжаннаши ба түүний зохиолын тухай” илтгэлийг (“Олон Улсын Монгол Хэл Бичгийн эрдэмтний их хурлын эмхэтгэл”.УБ.1961. 260-293 тал) тавьж хэлэлцүүлсэн явдал нь их зохиолч В.Инжаннашийн намтар, бүтээлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлахын эхлэл, таатай суурийг тавьж өгсөн явдал байлаа.



БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу гуай олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар Их хуралд оролцсон гадаад дотоодын төлөөлөгчдийг Их тэнгэрийн амны харшид хүлээн авсан нь. 1959.09.15

ТАЙЛБАР: Олон Улсын Монгол Хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал 1959 онд Улаанбаатар хотноо чуулахад гадаад, дотоодын монголч эрдэмтэд хүрэлцэн ирснийг тухайн цагийн БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга асан Ж.Самбуу хүлээн авч хүндэтгэлийн зоог барьсны дараа “Их тэнгэр цогцолбор”-т энэхүү зургийг авахуулсан нь хувийн архивт хадгалагдаж үлдсэн байна.

Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, профессор Балданы Содном Монголын эртний уран зохиолын судлалаар “Монголын утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв” (“Шинжлэх ухаан” УБ. 1946. 10-13) гурван бөлөг бүхий өгүүлэл бичсэн нь академич Ц.Дамдинсүрэн багшийн “Монголын уран зохиолын түүхэн тойм” I, II, III боть уншигч, судлаачдын гар дээр ирэх хүртэл Монголын эртний уран зохиолын судалгааны үндсэн судлагдахууны нэг болж байлаа.

1958 онд эрдэмтэн судлаач Ф.Намжилцэвээн “Хөх сударын судлал” нэртэй гурван зуу орчим нүүр бүхий ганц сэдэвт бүтээлийг Монголын эрдэмтэн, академич Ц.Дамдинсүрэнгийн удирдлагаар бичиж, “Инжаннашийн урлагийн талаар баримталж байсан үзэл, онол” нэртэй диссертацийн хураангуйг хэвлүүлж уншигч, судлаачдын

хүртээл болгосон байна. Энэ нь Монгол Улсад В.Инжаннашийн намтар, бүтээлийн судлалаар хийсэн, хэвлэж гаргасан анхны судалгааны ажил байсан байна. Эрдэмтэн Ф.Намжилцэвээний “Хөх сударын судлал”-ын талаар онцгойлон тэмдэглэж үлдээсэн нь, << “Хөх судар”-ын гар бичмэл хувилбар оршил, товчит толт үгүй арван таван бөлгийг муутуу цаасан дээр бичсэн байгаа бөгөөд энэ нь магадгүй 1919 онд хуулбарлан Богд хааны ордны номын санд хадгалж байсан, угтаа Баянхонгор аймгийн Мандал сумын хийдийн хутагт агсан Чин сүжигт Номун хан хэмээн алдаршисан Цэдэнбалжир 1918 онд “нусгай” хэмээх Дагдангаар хуулуулан өгсөн гар бичмэл болов уу. Бас Их шавийн зайсан Лувсан, Түшээт хан аймгийн Чин ван Ханддорж, Их Хүрээний Маймаа хотын зайсан Балдандорж нарт бүрэн бус “Хөх судар”-ын гар бичмэл байсан гэдгийг 1900 онд Шарав гэдэг хүн мэдээлсэн” >> гэснийг (УБ.1958.35 тал), (УБ.2008.41,42 тал) өгүүлсэн нь бас нэг сонирхолтой баримт болсон билээ.

Монгол Улсад 1921 онд ялсан Ардын хувьсгалын жилүүдэд Их Хүрээнд ажиллаж, амьдарч байсан Коминтерны төлөөлөгч асан буриад Жамсраны Цэвээн 1909 онд “Хөх судар”-ын 15 дэвтэр гар бичмэл Санкт-Петербургийн (Оросын Ленинград хот) төв номын санд хадгалагдаж байсныг олж үзсэнээ бас тэмдэглэсэн байдаг.

Академич Ц.Дамдинсүрэнгийн эрдэм шинжилгээ, судалгааны өргөн далайцтай нөр их ажлын нэг чиглэл нь Монголын эртний уран зохиолын судлал байсан бөгөөд тэрбээр монголын эртний уран зохиолын түүхийг бичиж улмаар 1959 онд их зохиолч В.Инжаннашийн түүхэн уран сайхны роман болох “Хөх судар”-ын хэсгээс авч тайлбар өгүүллийн хамтаар хэвлүүлж, << “Хөх судар” хэмээх том романыг зохиосон XIX зууны үеийн монголын зохиолч, сэтгэн бодогч Ванчинбалын Инжаннашийн гоо зүйн зарчимууд монголын утга зохиолын судлалд ихээхэн сонирхолтой юм. Романыхаа оршилд зохиолч урлаг, утга зохиолыг ойлгох өөрийн ойлголтыг илэрхийлсэн байдаг нь дэвшилтэт ардчилсан шинж чанараараа онцлог юм.” >> (УБ. 1999. 15 тал) хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Утга зохиол судлаач Г.Жамсранжав 1961 онд хэвлэгдсэн “Монголын уран зохиолын тойм” бүтээлийн гутгаар дэвтэрт их зохиолч В.Инжаннашийн товч намтар, бүтээлийн талаар судалгааны өгүүлэл бичиж, тусгай бөлөг болгон нийтлүүлсэн байна. Гэхдээ тэрбээр “Хөх судар” романы уйгаржин монгол бичгийн хэвлэлээс (Кайлу барын 69 бөлөгт “Хөх судар”-ын хэвлэл бололтой) зарим үг, өгүүлбэрийг эндүү, ташаа уншиж буулгасан нь утгын гажуудал үүсгэснийг ч бас дурдахгүй өнгөрөхийн аргагүй билээ.

Цаашлаад Монгол Улсын эрдэмтэн Д.Цагаан (Ноён хутагт Равжаа судлаач) Ерөнхий боловсролын дунд сургуулийн уран зохиолын сурах бичигт “Хөх судар”-ын гутгаар бөлгийг оруулан, хэвлэн нийтлүүлж олны хүртээл болгосон байна.

Академич Д.Цэрэнсодном судалгааны бүтээлдээ: “Инжаннаши түүхийн бодот явдал, бодгалын намтрыг тоочин өгүүлсэнгүй, уран сайхны дүр бүтээх аргаар бичсэн нь дундад зууны үеийн түүхийн зохиолуудаас ялгаатай бөгөөд ялангуяа “Хөх судар” романаараа төрөл зүйл, хэл найруулга, уран сайхны аль алинаар нь XIX зууны уран бүтээлд шинэчилэл хийсэн байна” (УБ. 1987.435 тал), (УБ. 2008. 44 тал) хэмээн В.Инжаннашийн судлалд түүний зохиолчийн их авъяас, зохиол бүтээлийнх нь өвөрмөц онцлогийн нь талаар үгээ хэлсэн байна.

Их зохиолч В.Инжаннашийн нийгэм-улс төр, гүн ухаан, ёс суртахууны үзэл баримтлалыг тухайн XIX зууны үеийн нийгэм, цаг үеийн нь үүднээс үнэлэн дүгнэж, түүний Монгол утга соёлын түүхэнд оруулсан хувь нэмэр, бүтээлч үйл ажиллагааг нь авч үзсэн судлаачид цөөнгүй билээ.

Гүн ухааны эрдэмтэн, судлаач Ч.Жүгдэр судалгааны өгүүлэлдээ: “Инжаннаши бол тэр үеийн Монголын нийгэмд ноёрхож байсан шашины бурангуй үзлийг эсэргүүцсэн, жирийн хүний оюун ухааны бүтээлч үйл ажиллагааг өргөсөн, бурхан болох, нөгөө ертөнцийн тухай бус, харин амьдарч бүтээж буй энэ ертөнцийнхээ тухай бодож сэтгэхийг уриалж, олон зуун жил ноёрхсон шашины мухардлаас гарах арга замыг хайсан соён гэгээрүүлэгч хүн байв.” (1973.81 тал), (2008.44 тал) гээд бас цааш нь, “Түүний нийгэм-улс төрийн сэтгэлгээ нь хэдийгээр түүхэн хязгаарлагдмал талтай боловч илчлэн шүүмжлэгч, гэгээрүүлэгч үзэл санаа, шашингүйн үзэл нь тэр үеийн Монголын нийгмийн тэргүүний ангид үйлчилж байсан тэргүүний үзэл санаа байсныг тодруулан өгүүлж, чухам үүнд л Инжаннашийн түүхэн ач холбогдол оршино.” (УБ.1966. 46 тал) хэмээсэн нь их зохиолч В.Инжаннашийн гүнээ сэтгэгч, соён гэгээрүүлэгч хийгээд түүний ертөцийг үзэх үзэл баримтлалынх нь талаар тусгайлан авч үзэж судалсан судлаачийн үнэлэлт, дүгнэлт болж байна.

Их зохиолч В.Инжаннашийн намтар, бүтээлийн судлалд угсаатан судлалын нэрт эрдэмтэн Х.Нямбуу үгээ хэлж: “Монголын уран зохиолын товчоо бичлэгийн уламжлалыг нанхиадын роман бичлэгийн жишээтэй чадварлаг хослуулан он дарааллын бичгийн арга барилыг урагш дэвшүүлэн Монгол романыг бүтээсэн” (УБ.1990.2.№8.118 тал), (УБ. 2008. 43 тал) хэмээн өгүүлсэн байдаг.

Мөн эрдэмтэн, судлаач Ж.Төмөрбаатар ”Хөх судар” романы талаар “Инжаннашийн урлаг, гоо зүйн үзэл” гэдэг өгүүлэлдээ: “Хөх судар түүхэн роман бол уран сайхны боловсруулалтын хувьд ч түүх, философи, урлаг, гоо зүйн онолын олон чухал асуудлыг хөндөж боловсруулсныхаа хувьд ч шилдэг бүтээл болсон юм.” (УБ.1990. 2. №8. 176 тал), (УБ. 2008. 43 тал) гэж бичсэн байдаг.

Эрдэмтэн, судлаач Л.Хүрэлбаатар 1996 онд бичсэн “Улайх униарын өнгө гэрэл” хэмээх судалгааны өгүүлэлдээ их зохиолчийн хүүрнэл зохиол болоод шүлэг найргийнх нь талаар тусгайлан авч үзсэнээ өгүүлэхдээ: “Ер нь Инжаннашийн байгаль гүн ухааны сэдэвтэй шүлгүүд нь байгалийн үзэгдлээр дамжиж, хүний сэтгэлийн дотоод мөн чанарт нэвтрэн орох талаараа онцгой бөгөөд шүлгээр дамжин илэрч байгаа санаа нь тухайн нийгмийн сүүдэр толбо туссан, гутрал гунигийн аясыг зарим талаараа хадгалсан байна. Нөгөө талаар Инжаннаши нь Дорно дахины шүлгийн зарим уламжлалт хэлбэрийг монгол шүлэгт идээшүүлэн авч монгол яруу найргийг шинэ хэлбэрээр баяжуулсан байна.” (УБ.1996. 211-212 тал) гээд цааш нь өгүүлэхдээ: “Хөх судар” романд үргэлжилсэн, шүлэглэсэн хоёр хэлбэрийг хослуулж, ардын аман зохиолын олон төрөл зүйл, ерөөл, магтаал, дуу, оньсого, таавраас гадна монголчуудын эртний төр иргэний болон шашин шүтлэгийн уламжлал, зан үйлтэй холбогдсон өчиг мэдүүлэг, айлтгал соёрхол, гэрээс тангараг, захиа зөвлөмжийн олон хэлбэрийг чадамгай ашиглаж, ёр билиг, рид хувилгаан, ид шидийг үзүүлсэн домог зүйн дүр, дүрслэлийг шигтгэн оруулж, хүний сэтгэлийн баяр жаргал, гуниг зовлон, явдал үйлдлийн хөгтэй сонин, бодол эргэцүүллийн нууц далдыг маш урнаар нээн харуулж түүхэн хэрэг явдлыг уран сайхнаар үзүүлсэн байна.” (УБ.1996. 217 тал) хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Миний бие, Дэ ван хэмээн алдаршсан Дэмчигдонров ноёны гэр өргөөний хэвлэлийн газарт барласан В.Инжаннашийн “Их Юан улсын мандсан төрийн Хөх судар” романы 18 бөлөгт хорголжин барын хувилбарыг сурвалжлан олж авснаа тусгайлан судалж 2005 онд < “Хөх судар”-ын хоёр эхийн утга, уран сайхны харьцуулсан судалгаа> хэмээх ганц сэдэвт бүтээл туурвиж, “Хөх судар” романы тухайд : “Их Юан улсын мандсан төрийн Хөх судар”-ын хоёр эхийг харьцуулж үзэхэд

нэг зүйлийн тухай өгүүлж байгаа боловч үгийн байрлалыг тодорхой бус шалтгаанаар сольсон, түүгээр ч үл барам зарим үг, үгсийг орхигдуулсан, үг хийгээд бөлөг үгсийг нэмсэн, эсвэл хассан, үгийн нөхцөл, дагаврыг өөрчилж хэрэглэсэн зэргээс үүдээд уг зүйлийн үндсэн утга ойлгомжгүй болох, зарим тохиолдолд утга нь алдагдахад хүргэсэн байна.” (УБ. 2008. 107 тал) гээд цааш нь “”Хөх судар”-ын 18 бөлөгт хорголжин бар нь “жинхэнэ эх”-дээ нэлээд ойртож очих талтай юм байна.” (УБ. 2008. 164 тал) гэсэн дүгнэлтэнд хүрсэн бөгөөд энэ нь “Хөх судар”-ын судлалд нэгэн шинэ хуудсыг нээсэн билээ.

Уг бүтээлээ 2003 онд Чоу Янь хотын Бэй Пио-д болсон “В.Инжаннашийн мэндэлсний 166 жилийн ойд зориулж В.Инжаннашийг дурсан ярилцахын учир Олон Улсын эрдэм шинжилгээний хурал”-д оролцож Бэй Пио дахь В.Инжаннашийн гэр музейд дурсгаж хадгалуулсан болно.

Хэдийгээр В.Инжаннашийн судлал энэ хэмжээний байгаа боловч их зохиолч Ванчинбалын Инжаннашийн намтар, бүтээлийн судалгааны ажил Монгол Улсад эхлэлийн төдий байна гэж үзэж байна.

Монголын эртний уран зохиолын хөгжлийн түүхийг судалж ирсэн эрдэмтэд, судлаачдын судалгааны бүтээлүүдийг анхааралтай ажиглахад нэг мөр болж шийдэгдээгүй, тулгамдсан асуудал өнөө хэр цөөнгүй байсаар байгаа билээ. Тухайлбал, их зохиолч В.Инжаннашийн судлалд л гэхэд “Инжаннаши “Хөх судар”-ыг бичсэн”, үгүй бол “Инжаннаши “Хөх судар”-ыг бичээгүй” гэх юм уу, эсвэл “Инжаннаши бол Хасбуу”, “Ванчинбал бол Хасбуу” ч гэдэг юм уу, мөн ч ах дүү Гуларанс, Инжаннаши нарын шүлэг найргийг хольж солих, нэгнийх нь бичсэнийг бичээгүй болгох, нөгөөгийнх нь бичээгүйг бичсэн болгох зэрэг цөөнгүй асуудлуудыг дурдаж болох байна.

Газар нутгийн харилцан хамаарал хоёр улсын харьяалалд нэгэнт харьяалагдах болсон энэ эрин цаг үед гал голомтын Монголд энэхүү агуу их зохиолчийн бүтээл, туурвилыг иж бүрнээр нь тогтолцоотой судлах, олны хүртээл болгох, дэлгэрүүлэх ажил ихээхэн чухал байгаа бөгөөд үүнийг цаашдаа судлаачдын хамтын багийг бүрдүүлж ажиллах нь зүйтэй мэт санагдаж байна.

НОМ ЗҮЙ

1. Дамдинсүрэн.Ц “Хуучин уран зохиолын доторх ардчилсан чиглэл”. (“Шинжлэх ухаан”.¹¹. УБ.)
2. Дамдинсүрэн.Ц. “Монголын уран зохиолын тойм”. I. II боть(УБ. 1959. 1961)
3. Дамдинсүрэн.Ц “Монголын уран зохиолын өв уламжлалын асуудалд”. (УБ. 1987)
4. Жүгдэр.Ч “Монголын нийгэм-улс төрийн ба гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн зарим асуудал”. (“ШУА-ийн мэдээ”. УБ. 1966)
5. Жүгдэр.Ч “XIX-XX зууны зааг дахь монголын нийгэм улс төр, философийн сэтгэлгээний хөгжил”. (УБ. 1972)
6. Нямбуу.Х “Монголчуудын гоо зүйн сэтгэлгээний өв уламжлалаас”. (Монголын философийн түүхийн зарим асуудал. ЭШБ. II боть. УБ. 1990)
7. Содном.Б “Монголын утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв” (“Шинжлэх ухаан”. УБ. 1946. ¹¹⁰⁻¹³)
8. Сэрээтэр.Ч (“Эх орон ард түмэндээ хүргэх үг”. УБ. 2009)

9. Төмөрбаатар.Ж “Инжаннашийн “Хөх судар”-ын урлаг, гоо зүйн үзэл”. (“Монголын философийн түүхийн зарим асуудал”. ЭШБ. II боть. УБ. 1990)
10. Хүрэлбаатар.Л (“Огторгуйн цагаан гарди”. УБ. 1996)
11. Цэдэв.Д “Балданы Содном” I.II.III боть. (УБ. 2008-2009.)
12. Хишигсүх.Б “Хөх сударын хоёр эхийн утга уран сайхны харьцуулсан судалгаа” (УБ. 2005. 2008)

SUMMARY

The contemporary study of Injannashi V., the greatest author of Mongolia, is on early stage of its development and calls for a consolidated thorough research project on his life and bibliography.

Moreover, biography and works by honorable scholar Erdenetogtokh, who pioneered the study of Injanashi, deserve to be studied.